




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын шийдвэрээр 2025 онд орон нутгийн хөрөнгөөр 383 төсөл, арга хэмжээнд 194,355.6 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвлөн баталсан байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 109,748.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 226 ТАХ тусгагдсан байна.



60%

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнээс 71,736.8 сая төгрөгийн 230 ТАХ 100% хэрэгжиж гэрээг дүгнэсэн байна.



85.4%

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээр 78,253.5 сая төгрөгийн 193 гэрээ байгуулж, аймгийн хэмжээнд 3,846.7 сая төгрөг хэмнэсэн байна.



41%

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 124,790.0 сая төгрөгийн 227 ТАХ-ний хөрөнгийг байгууллагын бүртгэл тайланд тусгаж, 5,010.2 сая төгрөгийн 3 ТАХ-г хөрөнгөд бүртгээгүй байна.



11.5%


Худалдан авах ажиллагааг хугацаанд нь /05.01нд/ зохион байгуулж дуусаагүй 26 ТАХ-ний 19,001.7 сая төгрөгийг Болзошгүй аваарын зардал шилжүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна

АУДИТЫН ДҮГНЭЛТҮҮД

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДСАН ХЭДИЙ Ч НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭМНЭЛТИЙГ БОЛЗОШГҮЙ АВААРЫН ЗАРДАЛД ШИЛЖҮҮЛЭН ЗАРЦУУЛЖЭЭ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ АЛДАГДСАН БАЙНА.



АУДИТЫН ШИЙДВЭР

32,754.2₮ /сая.төгрөг/ 13 албан шаардлага

1.94₮ /сая.төгрөг/ 2 төлбөрийн акт

1 Хариуцлага тооцох албан шаардлага

2,530.9₮ /сая.төгрөг/ 6 зөвлөмж



ЗӨВЛӨМЖ

❖ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛД:

- Төсвийн хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний төсвийг бөөн дүнгээр батлахгүй байх.

❖ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Зөвлөх үйлчилгээний төсвийг төсөл арга хэмжээ түс бүрээр төлөвлөж байх.
- Гэрээ сунгах үйл ажиллагаанд оролцох албан тушаалтныг томилох.

❖ ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх.

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжтой төсөл арга хэмжээг болзошгүй аваарын зардалд шилжүүлэн хэрэгжүүлэхгүй байх.

❖ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНД:

- Тусгай зөвшөөрөлгүй компаниар цахилгаан, шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлэхгүй байх.